

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ТАНИЛЦУУЛГА

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2018 онд
Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах
гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ,
үнэлгээ хийсэн тухай

2018 оны 12 дугаар сарын 24-ны өдөр.

Улаанбаатар хот

Нэг. Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго:

Төсвийн Ерөнхийлөн захирагч буюу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан 2018 оны хамтран ажиллах гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлэлт өгөх.

Хоёр: Хяналт шинжилгээ, үнэлгээний дүн:

2018 оны хамтран ажиллах гэрээний биелэлтэд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/486 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам шинэчлэн батлах тухай" Засгийн Газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу дүгнэв.

Аймгуудын үнэлгээг хүснэгтээр харуулбал:

№	Аймгуудын нэр	Гэрээнд тусгасан нийт арга хэмжээ	Биелэлт тасарсан арга хэмжээ	Үнэлгээ /хувь/	Тайлбар
1	Архангай	93	5	83.7 %	
2	Баян-Өлгий	71	5	78 %	
3	Баянхонгор	74	5	69.8 %	6 ажлын биелэлт ирүүлээгүй
4	Булган	121	2	84 %	
5	Говь- Алтай	49	4	81.4 %	
6	Говьсүмбэр	30		86.8 %	
7	Дархан-Уул	80		92 %	
8	Дорнод	90	1	86.9 %	
9	Дорноговь	54	2	81.3 %	
10	Дундговь	42		90%	
11	Завхан	77	1	78.9 %	2 ажлын биелэлт ирүүлээгүй
12	Орхон	104	2	85.5 %	
13	Өвөрхангай	71	3	71.7 %	8 ажлын биелэлт ирүүлээгүй
14	Өмнөговь	69	2	77.2 %	
15	Сүхбаатар	85	9	61.2 %	

16	Сэлэнгэ	79	4	80.6 %	
17	Төв	85	3	89.5 %	
18	Увс	95	2	90.1 %	
19	Ховд	64	2	77.1 %	
20	Хөвсгөл	106	1	88 %	
21	Хэнтий	131	1	85.8 %	2 ажлын биелэлт ирүүлээгүй
22	Нийслэл	46	5	60.9 %	14 ажлын биелэлт ирүүлээгүй
Аймгуудын дундаж үнэлгээ				80.9 %	

Д/д	Аймгуудын нэр	Үнэлгээ /Хувь/
1	Дархан-Уул	92 %
2	Увс	90.1 %
3	Дундговь	90 %
4	Төв	89.5 %
5	Хөвсгөл	88 %
6	Дорнод	86.9 %
7	Говьсүмбэр	86.8 %
8	Хэнтий	85.8 %
9	Орхон	85.5 %
10	Булган	84 %
11	Архангай	83.7 %
12	Говь- Алтай	81.4 %
13	Дорноговь	81.3 %
14	Сэлэнгэ	80.6 %
15	Завхан	78.9 %
16	Баян-Өлгий	78 %
17	Өмнөговь	77.2 %
18	Ховд	77.1 %
19	Өвөрхангай	71.7 %
20	Баянхонгор	69.8 %
21	Сүхбаатар	62.8 %
22	Нийслэл	60.9 %

ДҮГНЭЛТ:

-Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний биелэлт дунджаар 80.9 хувь буюу "В" үнэлгээтэй хэрэгжсэн байна.

Дархан-Уул, Увс, Дундговь аймгуудад байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт 90-ээс дээш хувиар биелэсэн байна.

Дийлэнх аймгуудад усны сан бүхий энгийн хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх, булаг шандыг тохижуулах, аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүд зохион байгуулах, агнуурын амьтны тоо толгой, тархац нөөцийн судалгаа хийгдсэн зэрэг ажлууд байна.

Харин хамтран ажиллах гэрээний биелэлтээс харахад агнуурын бүс нутгийг хууль тогтоомжийн дагуу байгуулах, зэрлэг амьтанд зориулсан худаг, хөв цөөрөм байгуулах, ан амьтны тооллого явуулах, авто зам дагуу аялал жуулчлалын үйлчилгээний цогцолбор байгуулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, сөрөг нөлөөллийг бууруулах, ойг нөхөн сэргээх ажлууд хангалтгүй биелэгдсэн байна.

Ялангуяа нийслэл, Сүхбаатар, Баянхонгор, Өвөрхангай, Ховд, Өмнөговь, Баян-Өлгий, Завхан аймгуудад гэрээний хэрэгжилт 60-78 хувьтай буюу хангалтгүй байна. Иймд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд онцгойлон анхаарах

-Нийслэлийн Засаг даргын тамгын газраас гэрээний биелэлтийг хугацаа хоцроож ирүүлсэн тул цаашид хугацаанд нь ирүүлэхэд анхаарах

САНАЛ, ЗӨВЛӨМЖ:

1. Аймгууд гэрээнд заасан арга хэмжээний биелэлтийг ойлгомжтой, тодорхой, нотлогдохуйц тайлагнаагүй,

2. Нийслэл буюу Улаанбаатар хот, Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Хэнтий аймгууд гэрээнд тусгагдсан ажлын биелэлтийг бичиж ирүүлээгүй, орхигдуулсан байгаад цаашид анхаарах

3. Сүхбаатар, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Архангай, Сэлэнгэ аймгууд болон нийслэлд биелэлт хангалтгүй, хэрэгжилт тасарсан 4-9 ажил байгаад анхаарч, хэрэгжилтийг эрчимжүүлэх, дараа жилийн төлөвлөлтөд оруулах

4. Аймгуудын гэрээний 1 болон 2 дугаар хавсралтад заасан ажлууд давхардсан, хэт ерөнхий, шаардлагагүй олон асуудал тусгасан, Засгийн Газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан ажлыг орхигдуулсан байгааг цаашид анхаарч, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах 2019 оны гэрээнд тухайн зорилт, арга хэмжээг зөв тодорхойлж, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхой болгоход тус яамны Төрийн Захиргааны Удирдлагын Газар анхаарч ажиллах